

**ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧЛАГЫН АЖЛЫН  
АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТАЙЛАН**

## Товч танилцуулга

Монголын ОУИТБС-ын Ажлын албыг 2019 оны эхээр Ерөнхий Сайдын ажлын албанаас хуучин нэрээ Уул уурхай хүнд үйлдвэрийн яаманд шилжүүлсэн билээ.

Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Азийн хөгжлийн банк Монголын ОУИТБС-ын үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Олборлох салбарын засаглалыг сайжруулах ТА 9752 MON” төслийн гэрээг 2019 оны 7 дугаар сард байгуулж, хэрэгжүүлсэн байна.

Мөн Дэлхийн банк, Сангийн яам “ОУИТБС-ыг хэрэгжүүлэх замаар олборлох салбарын ил тод байдлыг сайжруулах P176874” тоот төслийн гэрээг 2022 оны 5 дугаар сард байгуулж, ОУИТБС-ын Ажлын албыг төсөл хэрэгжүүлэх нэгжээр ажиллуулахаар тохирон 2022 оны 10-р сард эхлүүлсэн байна. Төслийг 2023 оны 12-р сарын 31-нд хэрэгжүүлж дуусгасан байна.

Харин 2024 оны 1-р сарын 1-нээс эхлэн үйл ажиллагаа дан ганц Улсын төсвөөр санхүүжиж, 2025 онд үргэлжлэх төлөвтэй байна.

Эдгээр цагаа олсон дэмжлэг туслалцаануудын үр дүнд Монголын ОУИТБС-ын үйл ажиллагаа жигдэрсэн байна. ОУИТБС-ын стандартын дагуу бэлтгэдэг жил бүрийн нэгтгэл тайлангуудыг хугацаандаа гарсан байна. Үүнд:

- 2019 оны эцсээр 2018 оны нэгтгэл буюу 13 дугаар тайлан,
- 2020 оны эцсээр 2019 оны нэгтгэл буюу 14 дүгээр тайлан,
- 2021 оны эцсээр 2020 оны нэгтгэл буюу 15 дугаар тайлан,
- 2022 онд 2021 оны нэгтгэл буюу 16 дугаар тайлан,
- 2023 онд 2022 оны нэгтгэл буюу 17 дугаар тайлан,
- 2024 онд 2023 оны нэгтгэл буюу 18 дугаар тайланг монгол, англи хэл дээр тус тус боловсруулан батлуулж, хэвлэн нийтэлсэн байна.

Тайлангуудыг ОУИТБС-ын Ажлын албаны цахим хуудас [www.eitimongolia.mn](http://www.eitimongolia.mn/p/33) <http://www.eitimongolia.mn/p/33> гэсэн хаягаар байршуулсан байна.

ОУИТБС-ын Ажлын албанаас 2024 онд төлөвлөсөн гол үйл ажиллагааны чиглэлийг танилцуулбал, Үүнд:

- ОУИТБС-ын стандартын шаардлагын дагуу 2023 оны Монгол Улсын ОУИТБС-ын нэгтгэл тайланг гаргах,
- Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах, батлуулах, Олон улсын Баталгаажуулалтын мөрөөр өгсөн 33 нэрийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд чиглэж байна.
- ОУИТБС-ын дэд зөвлөлүүдийг үйл ажиллагааг 2021 онд сэргээж, чадавхыг нэмэгдүүлсний хувьд Дэд зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, цахимаар 2 сар тутам уулзаж, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдээллээ солилцдог болгох;

Төслийн дагуу бүтээгдэхүүн бүрээр 2024 онд хийсэн үйл ажиллагааны тоймыг ерөнхийд нь танилцуулъя. Үүнд:

## **Бүтээгдэхүүн I. ОУИТБС-ын стандартыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сайжруулах**

### **ОУИТБС-ын 2023 оны тайлагнал**

Ажлын албаны тооцоолсноор ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тосны гэрээлэгч 2159 компани буюу зөвхөн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 1027, зөвхөн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 777, ашиглалтын болон хайгуулын лиценз эзэмшигч 340, үүсмэл орд эзэмшигч 1, бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий 17 компани ОУИТБС-ын 2023 оны тайлангаа шинэ маягтаар гаргана.

ОУИТБС-ын тайлангаа 1096 компани ОУИТБС-ын цахим тайлагналын системээр гаргасан нь сүүлийн жилүүдийн хамгийн бага тоо болж байна.

Ажлын албанаас 2023 оны тайлангаа гаргах албан хүсэлтийг 2 яам, 7 агентлаг (татвар, ашигт малтмал, газрын тос, гааль, төрийн өмч, хөдөлмөр нийгмийн халамж, стандарт хэмжил зүй, нийгмийн даатгал, халамж), 21 аймаг, нийслэл, 9 дүүрэгт илгээж, Монголын ОУИТБС-ын цахим тайлагналын системээр гаргах аргачлалыг холбогдох маягт, зааварчилгаа, нэвтрэх нууц үгийн хамт хүргүүлсэн байна.

Энэхүү үйл ажиллагааны үр дүнд одоогийн байдлаар 5 агентлаг (Татварын ерөнхий газар, Улсын стандарт, хэмжил зүйн газрын Сорьцын алба, Ашигт малтмал, газрын тосны газар, Гаалийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар), 18 аймаг, 8 дүүрэг ОУИТБС-ын тайлангаа 2093 компаниас хүлээн авсан орлогын дүнгээр гаргасан байна.

### **ОУИТБС-ын 2023 оны нэгтгэл тайлан боловсруулах байгууллагыг сонгох үйл ажиллагаа**

Монголын ОУИТБС-ын 2024 оны Ажлын төлөвлөгөөний дагуу 2024 оны 1 дүгээр улиралд 2023 оны ОУИТБС-ын тайланг бэлтгэх Засгийн газрын тендерийн бэлтгэл ажлыг хангасан байна. Үүнд:

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэд холбогдох хууль, журмын дагуу Үнэлгээний хороо байгуулах;
- Үйлчилгээний ажлын даалгавар, тендерийн баримт бичгийг боловсруулах;
- Тендерийн баримт бичгүүдийг УУХҮЯ-ны холбогдох удирдах албан тушаалтнаар батлуулах;

УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 2-р сарын 20-ны өдрийн А/12 тоот тушаалаар Үнэлгээний хороог байгуулсан бөгөөд хороонд УУХҮЯ-ны төлөөлөл 1, Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл 1, Ажлын албанаас 3 төлөөллийг тус тус оруулсан байна.

Монголын ОУИТБС-ын 2023 оны буюу 18 дугаар нэгтгэл тайланг ОУИТБС-ын тайланг бэлтгэх Зөвлөх үйлчилгээний Ажлын даалгаврыг УУХҮЯ-наас батлуулсан болно.

Тендерийн сонгон шалгаруулалтын ажил 4-р сарын 4-ны өдөр Засгийн газрын худалдан авах газрын [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим сайт дээр холбогдох зар хэвлэгдсэнээр эхэлсэн байна.

Тендерийн сонгон шалгаруулалтын үр дүнгээр СИКА ХХК, Гроут Файненс аудит ХХК- ийн түншлэл 4-р сард шалгарч, 5-р сарын 10-нд гэрээ байгуулж ажлаа эхэлсэн байна.

Гэрээт ажлын дагуу хамрах хүрээг тодорхойлох Ажлын хэсгийн холбогдох буюу 63 дугаар хуралдааныг 7 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулж, хамрах хүрээг ажлын даалгаврын тохирч, 125 тэргүүлэх компанийн тайлангуудыг хамруулахаар болсон байна.

Тайлангийн төслийг 10 дугаар сарын 23-ны өдөр хуралдсан Ажлын хэсгийн 64 дүгээр хуралдаан, 11 дүгээр сарын 29-ний өдөр хуралдсан Үндэсний Зөвлөлийн 22 дугаар хуралдаанд танилцуулж, гишүүдээр хэлэлцүүлсний дүнд баталсан байна.

**Нэгдүгээр бүтээгдэхүүний хэрэгжилтийн гол онцлог**– Монголын ОУИТБС-ын 2023 оны буюу 18 дугаар тайланг гаргах бэлтгэл ажлыг хангасан байна. 1096 компани, 5 агентлаг, 18 аймаг, 8 дүүрэг цахимаар 2093 компаниар тайлагнаад байна. Хэрэгжилт 100 хувь болно.

**Бүтээгдэхүүн II. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх**

**ЭБСИТБ-ын тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулах талаар ажилласан нь**

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим сайт дээр байршуулж санал авч байна.  
<https://mojha.gov.mn/content/651fbaff99e06106c641f63a>

Ажлын албанаас төслийг хэлэлцүүлэх ажлыг идэвхжүүлэх, олон нийтэд ойлгуулах зорилгоор 2024 оны 2-р сард ХЗДХЯ дээр энэ хуулийн төслийг төслийг Төрийн байгууллага, Иргэний нийгмийн байгууллагуудаар хэлэлцүүлж, саналыг авч, нэгтгэсэн болно. Засгийн газрын хуралдаанд танилцуулахад бэлэн болсон байна.

**Хоёрдугаар бүтээгдэхүүний хэрэгжилтийн гол онцлог:** Хуулийн төсөлд санал авч нэгтгэсэн, 2025 онд батлагдана гэсэн хүлээлттэй байна. Хэрэгжилт 100 хувь болно.

**Бүтээгдэхүүн III. Мэдээлэл түгээх ажлыг сайжруулах боломжийг судлах, олборлох салбарын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэх**

**Орон нутгийн дэд зөвлөлүүдтэй хэрэгжүүлж буй харилцаа холбоо**

Ажлын алба аймгуудын ОУИТБС-ын дэд зөвлөлүүдийн сургалт, уулзалтыг 2024 оны 3-р сарын 26-ны өдөр болон 4-р сарын 24-ны өдөр тус тус цахимаар зохион байгуулсан. Дэд зөвлөл бүхий 21 аймаг, сум дүүргийн 33 төлөөлөл оролцож, шинэ системээр тайлан гаргах аргачлал, зааварчилгааг авсан байна.

**Сургалт, семинар, харилцаа холбооны мэдээлэл**

Сургалтын үйл ажиллагаа

Компаниудын шинэ системээр тайлан гаргах сургалтыг Дазо ХХК- тай хамтран зохион байгуулсан. 202 компанийн төлөөлөл оролцсон байна.

Энэ оны 3-р сарын 6-7 өдрүүдэд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн семинарт оролцож, танилцуулга илтгэл тавьсан.

Энэ оны 5-р сарын 10 өдөр Хэнтий аймгийн засаг даргын тамгын газраас зохион байгуулсан компаниудын уулзалтад оролцож, компаниудын оролцооны талаар танилцуулга хийсэн байна.

Мөн энэ хүрээнд ОУИТБС-ын хэрэгжилтийн явц, ОУИТБС-ын Дэд зөвлөлийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй танилцуулан, хэлэлцүүлэгт оролцсон байна.

Орхон аймгийн дэд зөвлөлийг чадавхжуулах зорилгоор Эрдэнэт хотод 5-р сард Эрдэнэт Хүмүүний Эв Нэгдэл ТББ-тай хамтран сургалт зохион байгуулж, ажлын алба танхимаар болон цахимаар оролцов.

### **Ажлын хэсгийн 63 дугаар хуралдаан**

ОУИТБС-ын Ажлын хэсгийн 63 дугаар хуралдааныг 7 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулж, 2023 оны буюу 18 дугаар нэгтгэл тайлангийн эхлэлийн семинарыг СИКА ХХК, Гроут Файненс аудит ХХК-ийн түншлэлтэй хамтруулан хийж, хамрах хүрээний асуудлыг тохирч, тулган баталгаажуулалтад 125 компанийн тайланг хамруулах болсон.

Мөн Нэгтгэл тайлангийн ажлын даалгавар, Гэрээ, Төрийн өмчийн компанийн ил тод, Баталгаажуулалтын мөрөөр авах арга хэмжээний 4 дэд хэсэг байгуулахаар болсон байна.

### **Ажлын хэсгийн 64 дугаар хуралдаан**

ОУИТБС-ын Ажлын хэсгийн 64 дугаар хуралдааныг 10 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулж, 2023 оны буюу 18 дугаар нэгтгэл тайлангийн төслийг танилцуулан хэлэлцүүлсэн бөгөөд Үндэсний зөвлөлд танилцуулж батлуулах санал гаргасан билээ. Мөн ОУИТБС-ын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг танилцуулж санал аван боловсруулж, Үндэсний зөвлөлийн хуралдаанд бэлтгэсэн байна.

### **Үндэсний Зөвлөлийн 22 дугаар хуралдаан**

ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн 22 дугаар хуралдааныг 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулж, 2023 оны буюу 18 дугаар нэгтгэл тайлангийн төслийг танилцуулан Үндэсний зөвлөлөөр батлуулсан байна.

Мөн санал авч бэлтгэсэн ОУИТБС-ын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг батлуулсан байна.

### **Бусад харилцаа холбоо**

ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн газартай хамтран Төв Ази, Кавказын орнуудын туршлага солилцох семинарыг 6-р сард Улаанбаатар хотноо анх удаа зохион байгуулсан. Энэ арга хэмжээнд Монгол, Армен, Казакстан, Кыргызстан улсуудын төлөөлөл оролцож, гэрээ, эцсийн өмчлөгч, мэдээлэл өгөгдлийн ил тод байдлын талаар туршлага солилцож, цаашид хамтран ажиллахаар тохирсон байна. Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны төслийн багаас энэ семинар дээр танилцуулга хийлгэсэн байна.

Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны төслийн хүрээнд Ажлын хэсгийн гишүүд, төрийн байгууллага, төрийн өмчийн компаниудын мэргэжилтнүүдэд мэдээлэлийн өгөгдлийн 3 цуврал сургалтыг 6-р сард болон эрчим хүчний шилжилт, ТӨК, Гэрээний ил тод байдал, авилгаас сэргийлэх мөн 3 сургалтыг 8-р сард тус тус зохион байгуулсан болно.

Эдгээр арга хэмжээний хүрээнд Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгээс Төрийн өмчийн аж ахуйн нэгжийн ил тод байдал, Гэрээний ил тод байдлыг цаашид хөгжүүлэх чиглэлээр баримтлах Замын зураг- уудыг монгол, англи хэл дээр боловсруулж, Ажлын хэсэгт цахимаар танилцуулж, саналын авсан болно.

Засгийн газрын хоорондын “Нээлттэй Засгийн түншлэл”- ийн судалгаанд оролцож холбогдох тайлбар, танилцуулгыг боловсруулж өгсөн байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу зарим талбай буцаах тухай 2 ажлын хэсэгт орж ажилласан байна.

### **Харилцаа холбоо мэдээллийн үйл ажиллагаа**

Монголын ОУИТБС-ын 2022 оны Нэгтгэл тайлангийн тухай товч видео контентыг өөрийн боломж, бололцоогоор бүтээж, Ажлын албаны [www.eitimongolia.mn](http://www.eitimongolia.mn) болон Фейсбүүкийн хаягаар түгээсэн байна.

УУХУЯ, АМГТГ, МУУҮА-ын цахим хуудас, Эрдэс баялгийн тойм, [mongolian mining journal.com](http://mongolianminingjournal.com), [mining.mn](http://mining.mn), [mininginsight.mn](http://mininginsight.mn) сайтуудын веб хуудас дээр ААН-үүдийн тайлан гаргах тухай уриалга болон сургалтын зарыг байршуулсан байна.

Монголын ОУИТБС-ын 2023 оны Нэгтгэл тайлангийн шторкийг АҮЭБЯ-ны шугамаар захиалж хийлгэсэн байна.

### **Гуравдугаар бүтээгдэхүүний хэрэгжилтийн гол онцлог:**

Харилцаа холбоо, олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлэн ажиллаж байна. Хэрэгжилт 100 хувь болно.

### **Үйл ажиллагааны үнэлгээ-2024 он**

<b>Бүтээгдэхүүний дугаар</b>	<b>Гарах бүтээгдэхүүн</b>	<b>Хэрэгжилтийн ахицын гол түвшин</b>
I	ОУИТБС-ын стандартыг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа сайжруулах;	<ul style="list-style-type: none"><li>• Монгол Улсын ОУИТБС-ын 2023 оны тайланг боловсруулах үйлчилгээний сонгон шалгаруулалт, гэрээт ажлууд хугацаандаа амжилттай хэрэгжүүлсэн байна.</li><li>• 1096 компани, 5 агентлаг, 18 аймаг, 8 дүүрэг ОУИТБС-ын тайлангаа 2093 компаниар гаргасан.</li><li>• Монгол Улсын ОУИТБС-ын 2023 оны буюу 18 дугаар нэгтгэл тайланг 125 компаниар тулган баталгаажуулсан байна.</li></ul>

II	Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулсан байх;	Дурдсан хуулийн эцсийн хувилбарыг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хуулийн төсөл болгон өргөжүүлж, ХЗДХЯ дээр шинэчлэн бэлтгэсэн байна. Хуулийн төслийн холбоос: <a href="https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da">https://mojha.gov.mn/contentList/62dfcd0a3982fa3c90f2a7da</a>
III	Мэдээлэл түгээх ажлыг сайжруулах, олборлох салбарын талаарх мэдээллийг олон нийтэд түгээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;	Төлөвлөгөөт хурал, сургалтуудыг зохион байгуулсан. 4 дэд хэсэг байгуулсан.  Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, Европын сэргээн босголт хөгжлийн банкны төслийг хэрэгжүүлсэн байна. Энэ төслийн үр дүнд холбогдох сургалт, семинаруудыг зохион байгуулж, чадавхийг нэмэгдүүлэхийн хамт Төрийн өмчийн аж ахуйн нэгжийн ил тод байдал, Гэрээний ил тод байдлыг цаашид хөгжүүлэх чиглэлээр баримтлах Замын зурагуудыг монгол, англи хэл дээр боловсруулж

### **2025 оны үйл ажиллагааны ерөнхий чиглэл**

2025 оны үйл ажиллагааны эхний хамгийн чухал зорилт боло олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийг батлуулах, батлуулсны дараа саадгүй хэрэгжүүлэх зорилгоор бэлтгэл ажлыг хангана.

Хоёрдахь зорилт бол 2022 оны баталагаажуулалтаас өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх Монгол Улсын ОУИТБС-ын 2024 оны нэгтгэл буюу 19-р тайланг 2023 оны шинэ стандартын дагуу боловсруулах явдал юм.

Гуравдахь гол чиглэл бол ОУИТБС-ын харилцаа холбоо, өгөгдлийн ашиглалтыг сайжруулах, орон нутгийн дэд зөвлөлийн үйл ажиллагааг тогтворжуулахад оршиж байна.

### **ОУИТБС-ын Ажлын алба**